



**ОРХОН АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 106

Баян-Өндөр сум

**Чөлөөт бөхийн насанд хүрэгчдийн улсын
аймгийн аварга шалгаруулах тэмцээнд
хөрөнгө гаргах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Чөлөөт бөхийн 2025 оны насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2.Тэмцээнийг санхүүжүүлэх гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг спортын хэлтсийн дарга (Э.Лхамсүрэнбаатар), спортын холбоод, клубуудын сургалт, дасгалжуулалт асуудал хариуцсан мэргэжилтэн (О.Мөнхзул) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тэмцээнд зарцуулагдах 480,000 (дөрвөн зуун наян мянга) төгрөгийг зохих журмын дагуу үндэсний тэмцээн наадмын үйл ажиллагааны зардлаас гаргаж, гэрээний дагуу шилжүүлэг хийхийг ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн албаны дарга (Ж.Нямжаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ДЭЛГЭРБАЯР

Биеийн тамир, спортын газрын даргын
2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн
10/08 дугаар тушаалын хавсралт

ЧӨЛӨӨТ БӨХИЙН НАСАНД ХҮРЭГЧДИЙН 2025 ОНЫ УЛСЫН
АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хоног	Хүний тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1.	Байрны зардал	2	8	30,000	480,000
	Төсвийн нийт дүн				480,000

----oOo----